



ДОРНОГОВЬ АЙМГИЙН БИЕЙН  
ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

103 дугаар байр, Дэнжийн гудамж, 2 дугаар баг  
Утас: 77370751 Факс: 44105

Цахим шуудан: mail.gov.mn.dornogovi@sport.gov.mn  
Цахим хуудас: dornogovi@sport.gov.mn

2024.12.13 № 420

танай 2024.12.02 -ны № 1/1199 -т

Г БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ДАРГЫН  
УЛСЫН ХОРООНЫ ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ О.БАТТУЛГА ТАНАА

Тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, “Стратеги төлөвлөгөө”-ний 2023-2024 оны хэрэгжилтийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг тус тус гаргаж хүргүүлэв.

Хавсралт 15 хуудастай.



Дорноговь аймгийн биеийн тамир  
спортын газар  
Удирдлага  
Дарга  
Галан Батлхам  
2024-12-19 14:43:05

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2023-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Сайншанд сум

| №  | Бодлогын баримт бичиг тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт  | Хэрэгжүүлэх арга хэмжээ   | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин                    | Зорилгот түвшин   | Биелэлт  | Үнэлгээ |
|--|---|---|--|---------------------------------|---|--|---------|
| <b>Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах</b>  |   |   |  |                                 |   |  |         |
| <b>Үндсэн чиг үүргийн нэр: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох</b> |   |   |  |                                 |   |  |         |
| 1  | <b>Зорилт-1.</b><br>Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан | <b>Арга хэмжээ-1</b><br>Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлэх; | Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ хувиар тооцно | Суурь үзүүлэлт 2020 онд 53 хувь | 2021 онд 54.5 хувьд, 2022 онд 56 хувьд, 2023 онд 57.5 хувьд, 2024 онд 59 хувьд хүргэх | Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд нийт 6149 иргэд хамрагдсан. Сорилыг хувь хүний биеийн ачаалал даах чадвар болон биеийн дотоод бүтцийг тодорхойлох чиглэлээр авч, гарсан үр дүнгээр хүн бүрд зөвлөгөө өгч ажилласан. Бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А,В,С үнэлгээтэй иргэд 70%-ийг эзэлсэн. | 100%    |
|  |   | <b>Арга хэмжээ-2</b><br>Сумдад орон тооны биеийн  | Сумын биеийн тамирын арга зүйчийн тоог 6 болгосон байна.   | 2020 онд 8 биеийн тамирын       | 2022 онд 1-ээр нэмэгдүүлнэ  | Аймгийн Засаг даргын 2023 оны А/73 дугаартай захирамжаар Биеийн тамир, спортын газрын  | 80%     |

|   |   |  |  |  |   |   |
|---|---|--|--|--|---|---|
| <p>тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ</p> | <p>тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх</p>  |  | <p>арга зүйч суманд ажиллаж байна.</p> | <p>2023 онд 2-оор нэмэгдүүлнэ<br/>2024 онд 3-аар нэмэгдүүлнэ</p> | <p>бүтэц, орон тоог шинэчлэн баталж, Сайншанд сумын 1 баг, 7 суманд биеийн тамирын арга зүйчийн орон тоо шинээр бий болгосон. Сумдын хэмжээнд 9 биеийн тамирын арга зүйч ажиллаж байна. 2023 онд сумдад 7 арга зүйч ажиллаж байсан бол 2024 онд 9 болж 28,5%-р өссөн.</p> | <p>Мэдээлэл харилцааны технологийн дэвшлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлж иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын цахим хаяг болох Дорноговь Биеийн Тамир Спортын Газар пэйж хуудсаар үнэ төлбөргүй секц дугуйлангийн мэдээлэл болон видео зар, контентийг бэлтгэн сурталчилж, тухайн спортоор хичээллэх сонирхолтой хүүхэд багачуудын тоо нэмэгдэж, өнгөрсөн оны хагас жилийн байдалтай харьцуулахад спортоор хичээллэгсдийн тоо 20-30 хувиар нэмэгдсэн байна. Мөн аймаг орон нутагт зохион байгуулагдаж байгаа тэмцээн уралдаантай холбоотой мэдээ мэдээлэл, тоглолтын хуваариудыг цахим хуудсаараа дамжуулан иргэдэд хүргэснээр спорт сонирхогч, үзэгчдийн тоо эрс нэмэгдэж 8400 дагагчтай болж өнгөрсөн оноос 700</p> |
|   | <p><b>Арга хэмжээ-3</b><br/>Биеийн тамир, спортын газрын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн баазад спортын холбоо, клубүүдийн үйл ажиллагааны мэдээллийг баяжуулж оруулах</p> |  |  |  | <p>100%</p>   |   |

|  |  |   |   |   |   |  |             |
|--|--|---|---|---|---|--|-------------|
|  |  | <p><b>Арга хэмжээ-4</b><br/>Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлэх</p> | <p>Аймгийн хэмжээнд нийт 30 ажлыг холбоод, клубүүдэд шилжүүлнэ.</p> | <p>2020 онд 25 спортын холбоо, клубүүдтэй хамтарч ажилласан</p> | <p>2021 онд 1,<br/>2022 онд 1,<br/>2023 онд 1,<br/>2024 онд 2</p> | <p>дагагчаар нэмэгдсэн. Байгууллагын пэйж хуудсанд иргэдээс 100-150 санал хүсэлт, асуулт ирсэнд тухай бүрт хариулт өгч ажилласан. Мөн Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулж буй улсын чанартай тэмцээн уралдаанд аймаг орон нутгаас оролцогчдыг цахимаар бүртгэдэг үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, олон нийтийг дасгал хөдөлгөөнд идэвхитэй хамруулах, эрүүл аж төрөх дадлыг бий болгох зорилгоор зохион байгуулж арга хэмжээнүүдийг видео болон постер хэлбэрээр цахим хуудсаараа дамжуулан сурталчилснаар биеийн тамир, спортоор хичээллэх, дасгал хөдөлгөөн хийх иргэдийн тоо тогтмол өсч байна.</p> | <p>100%</p> |
|  |  |   |   |   |   | <p>Спортын холбоодтой хамтран Дорноговь опен Жюу жицүгийн олон улсын нээлттэй тэмцээн, Сагсан бөмбөгийн Үндэсний супер лигийн бүсийн финалын тоглолт, Говийн бүсийн шагайн харваан тэмцээн, Зүүн бүсийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн, Чөлөөт бөх, жүдо, шатар, даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, волейболын өсвөрийн болон</p>  |             |

|  |  |  |  |  |  |   |
|--|--|--|--|--|--|---|
|  |  |  |  |  |  | <p>насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, Сагсан бөмбөгийн Говь гаяс лиг, Волейболын хөгжлийн лиг, Шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд тус тус зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүх нийтийн гүйлт арга хэмжээ 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулагдлаа. Нийт 300 хүн оролцсон. Хутагтын нутаг-Шамбалын орноор 2024 100км-ын Явган алхалт зохион байгуулагдсан. Нийт Улаанбаатар хот, 3 аймгийн 122 алхагч оролцсон.</p> <p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд 38841 өсвөрийн болон насанд хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж давхардсан тоогоор 10099 иргэн хамрагдсан.</p> <p>Мөн шугаман бүжгийн спортоор давхардсан тоогоор 5676 иргэд,</p> |
|--|--|--|--|--|--|---|

|   |   |   |  |  |  |  |
|---|---|---|--|--|--|--|
|   |   |   |  |  | <p>спортын үйл ажиллагаанд 43484 иргэн хамрагдаж нийт хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажил, арга хэмжээнд 59259 иргэнд хамрагдсан.</p> |  |
| <p><b>Арга хэмжээ-5</b><br/>Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд спортын холбоо, клубүүдийн мэдээллийг оруулж баяжилт хийх</p> | <p>Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд 30 спортын холбоодын үйл ажиллагаатай холбоотой эх өгөгдөл байршуулна.</p> | <p>2020 онд 25 спортын холбоо, клубүүдтэй хамтарч ажилласан</p> | <p>2021 онд 1,<br/>2022 онд 1,<br/>2023 онд 1,<br/>2024 онд 2</p>                            | <p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилго зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа тогтмол байршуулан тухай бүр шинэчлэн, спортын холбоод клубүүдээс зохион явуулж буй тэмцээн уралдааны зардал, заал болон материаллаг баазаар ханган хамтран ажиллаж байна. Мөн "Соёлын Бүтээлч сар, Биеийн тамир спортын бүтээлч сар-2024" аяны хүрээнд улс, бүс, тив дэлхийн тэмцээнүүдэд амжилт гаргасан тамирчин дасгалжуулагчдыг алдаршуулж, <a href="https://www.facebook.com/BTSG2">https://www.facebook.com/BTSG2</a> 020 цахим хуудсаараа дамжуулан постер хэлбэрээр олон нийтэд сурталчилан таниулсан.</p> | <p>100%</p>  |  |
| <p><b>Арга хэмжээ-6</b><br/>Биеийн тамирын арга зүйчд мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх</p>   | <p>Биеийн тамирын 10 арга зүйчийг мэргэшүүлэх давтан сургалтад хамруулсан байна</p>   | <p>2020 онд Ковид-19 цар тахлын улмаас мэргэшүүл эх сургалт</p> | <p>2021 онд 2<br/>2022 онд 2,<br/>2023 онд 3,<br/>2024 онд 3<br/>арга зүйчдийн сургалтад</p> | <p>Тус газраас 2024 онд зохион байгуулах 8 заалт бүхий ажлын төлөвлөгөө, сар бүр мэдвэл зохих хууль тогтоомж болон хөгжүүлэх чиглэлээрх сургалтын календарчилсан төлөвлөгөөг 24</p>  | <p>100%</p>  |  |

|  |  |                                    |  |                   |                  |   |
|--|--|------------------------------------|--|-------------------|------------------|---|
|  |  | <p>Давтан сургалтанд хамруулах</p> |  | <p>явагдаагүй</p> | <p>хамруулна</p> | <p>заалтаар батлан, сургалтыг зохион байгуулан, сургалтын танхимд ухаалаг дэлгэц болон цахим сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг байрлуулж мэдээлэл технологийн дэвшилтэт хэрэгслээр явуулж сумдын албан хаагчдыг зоом-ээр сургалтанд хамрагдах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.<br/>Говь-Сүмбэр аймагт зохион байгуулагдсан шинэ спортын төрөл крикетийн спортын анхан шатны мэдлэг олгох сургалтанд тус газрын ахлах мэргэжилтэн, нийтийн биеийн тамирын арга зүйч, Төв аймагт зохион байгуулагдсан сорилын жишиг төв байгуулах сургалтанд төвийн болон сумдын 9 биеийн тамирын арга зүйч нар, Олон улсын С зэрэглэлийн сургалтанд сагсан бөмбөгийн дасгалжуулагч, Монголын Волейболын холбооны анхан шатны шүүгчийн сургалтанд нийтийн биеийн тамирын арга зүйч, Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан Бээжин хотын Спортын их сургуульд 10 хоног туршлага судлах хөтөлбөрт чөлөөт бөхийн дасгалжуулагч, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Биеийн тамир спорт тогтвортой хөгжил" Олон улсын эрдэм шинжилгээний хуралд ахлах мэргэжилтэн,</p> |
|--|--|------------------------------------|--|-------------------|------------------|---|

|  |  |   |  |  |  |  |
|--|--|---|--|--|--|--|
|  |  |   |  |  | <p>чөлөөт бөхийн дасгалжуулагчид, "Спортын анагаах ухаан" эрдэм шинжилгээний хуралд нийтийн биеийн тамирын арга зүйч, усан спорт сургалтын төвийн дасгалжуулагч нар, тус газраас Монголын мэргэжлийн шүүгчдийн холбоо, Дорноговь аймгийн сагсан бөмбөгийн холбоотой хамтран 10 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд сагсан бөмбөгийн Олон улсын шүүгчийг урин сагсан бөмбөгийн шүүгч бэлтгэх сургалтыг зохион байгуулж 24 дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйчдийг хамруулж сертификат олгож мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн ажиллаж байна.</p> |  |
| <p><b>Арга хэмжээ-7</b><br/>"Эрүүл Монгол" өглөөний дасгалыг ажлын өдрүүдэд 06:30-07:00 цагийн хооронд тогтмол явуулна.</p>  | <p>Дасгалд хамрагдагчдын тоон үзүүлэлтээр</p>            | <p>2020 онд давхардсан тоогоор 200 орчим иргэд хамрагдсан</p>               | <p>2021 онд 250<br/>2022 онд 300<br/>2023 онд 350<br/>2024 онд 400</p> | <p>Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор 7 хоног бүр Спортын ордонд өглөө 06<sup>00</sup>-08<sup>00</sup> цагийн хооронд шугаман бүжиг хичээллэж байна. Уг спортоор сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 5676 байна.</p> | <p>100%</p>  |  |
| <p><b>Арга хэмжээ-8</b><br/>Төрийн болон бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж спорт заалаар үйлчилж нийтийн</p> | <p>Гэрээ байгуулж хамтран ажилласан байгууллагын тоо</p> | <p>2020 онд 20 аж ахуй нэгж, албан байгууллага гэрээ байгуулж ажилласан</p> | <p>2021 онд 22<br/>2022 онд 24<br/>2023 онд 26<br/>2024 онд 28</p>     | <p>Спортын холбоодтой хамтран Дорноговь олон улсын нээлттэй тэмцээн, Сагсан бөмбөгийн Үндэсний супер лигийн бүсийн финалын тоглолт, Говийн бүсийн шагайн харваан тэмцээн, Зүүн бүсийн шатарчдын аварга шалгаруулах</p>   | <p>100%</p>  |  |



|  |  |                                 |  |  |  |
|--|--|---------------------------------|--|--|--|
|  |  | <p>биеийн тамрыг хөгжүүлнэ.</p> |  |  | <p>тэмцэн, Чөлөөт бөх, жүдо, шатар, Даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, волейболын өсвөрийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, Сагсан бөмбөгийн Говь гаяс лиг, Волейболын хөгжлийн лиг, Шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд тус тус зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүх нийтийн гүйлт арга хэмжээ 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулагдлаа. Нийт 300 хүн оролцсон. Хутагтын нутаг-Шамбалын орноор 2024 100км-ын Явган алхалт зохион байгуулагдсан. Нийт Улаанбаатар хот, 3 аймгийн 122 алхагч оролцсон. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд 38841 өсвөрийн болон насанд хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж</p> |
|--|--|---------------------------------|--|--|--|

|  |   |   |  |  |             |   |  |
|--|---|---|--|--|-------------|---|--|
|  |   |   |  |  |             | <p>Давхардсан тоогоор 10099, шугаман бүжгийн сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 5676 иргэд байна.</p> |  |
| <p>Зорилт-2.<br/>Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина</p> | <p><b>Арга хэмжээ-1</b><br/>Улс, олон улсын аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, улсын жишигт нийцсэн Монгол бахархалын төв барьж ашиглалтад оруулахад талбайн хэмжээ болон спортын талаарх мэргэжлийн тусламж үзүүлэх</p> <p><b>Арга хэмжээ-2</b><br/>Сайншанд, Замын-Үүд суманд хөлбөмбөг, граундгольфын талбай байгуулах, Сайншанд суманд буудлагын тир байгуулахад стандарт талбайн хэмжээ болон мэргэжлийн тамирчдын мэдээллийг авч цахим бүртгэлд</p> | <p>Стандартад талбайн хүртээмжийг хангах нийцсэн хэмжээ</p> |  | <p>Төрийн өмчийн 33 хүүхдийн цэцэрлэгт Монгол ёс заншил, бахархлын өргөө, танхимыг тохижуулан, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3000 гаруй хүүхэд, багачуудад үндэсний өв соёлоо сурталчлан таниулсан. “Соёмбо” цогцолборын хүндэтгэлийн өргөө, “Жаргалан” хүүхдийн зуслан, “Спорт цогцолбор”-ын үндэсний спортын танхимыг түшиглэн үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” төв байгуулахаар ажиллаж байна.</p> | <p>100%</p> |   |  |
| <p>2</p>   |   |   |  | <p>Төсөв шийдэгдээгүй тул хөл бөмбөгийн болон граундгольфын талбай байгуулагдаагүй, тус байгууллагаас шалтгаалсан зүйл байхгүй болно.</p>  | <p>70%</p>  |   |  |

|   |   |  |  |   |  |      |  |  |  |  |
|---|---|--|--|---|--|------|--|--|--|--|
|   | оруулах.  |  |  |   |  |      |  |  |  |  |
|   | <b>Арга хэмжээ-3</b><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий танхим байгуулах              | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий танхим байгуулах | 2020 онд танхимын талаарх зураг төсөв шийдэгдсэн | 2021 онд танхимыг байгуулах<br>2022 онд тоног, төхөөрөмж авах | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан Биеийн тамир, спорт цогцолборын гадна зам талбай мөн душ, ариун цэврийн өрөөг тохижуулсан. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоног төхөөрөмж бүхий танхимыг тохижуулах ажлыг төвлөлөн ажиллаж байна.   | 70%  |  |  |  |  |
| <b>Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах</b>   |   |  |  |   |  |      |  |  |  |  |
| <b>Үндсэн чиг үүргийн нэр: Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх</b>                |   |  |  |   |  |      |  |  |  |  |
| Зорилт-3.<br>Монгол үндэсний уламжлалт спортыг Улс, олон улсад таниулахад Аймагаас бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ | <b>Арга хэмжээ-1</b><br>Үндэсний уламжлалт спортын Монгол бахархалын төв байгуулах, аймгийн шигшээ багтай болох |  |  |   | Төрийн өмчийн 33 хүүхдийн цэцэрлэгт Монгол ёс заншил, бахархлын өргөө, танхимыг тохижуулан, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3000 гаруй хүүхэд, багачуудад үндэсний өв соёлоо сурталчлан таниулсан. "Соёмбо" цогцолборын хүндэтгэлийн өргөө, "Жаргалан" хүүхдийн зуслан, "Спорт цогцолбор"-ын үндэсний спортын танхимыг түшиглэн үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх "Монгол бахархал" төв байгуулахаар ажиллаж байна. Мөн Үндэсний бөхийн УАШТ тэмцээн, Өмнөговь аймгийн Даланзадгад хотын УАШТэмцээнд амжилттай оролцсон. | 100% |  |  |  |  |
| 3   |   |  |  |   |  |      |  |  |  |  |
|   | <b>Арга хэмжээ-2</b><br>Аймгийн хэмжээнд иргэдийн дунд  | Бага олимпд оролцох баг тамирчдын тоогоор оролцсон                         | 2019 онд спортын 10 төрлөөр                      | 2021 онд 12 төрлөөр<br>2022 онд 13                            | "Дорноговь бага олимп" спортын наадам тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.   | 70%  |  |  |  |  |

|  |   |   |  |   |  |  |             |
|--|---|---|--|---|--|--|-------------|
|  | <p><b>БАГА ОЛИМП</b><br/>спортын<br/>төрөлжсөн<br/>наадмыг 2 жилд<br/>нэг удаа зохион<br/>байгуулах</p>                                       |   | <p>2020 онд<br/>тэмээн<br/>поло<br/>тэмцээн<br/>зохион<br/>явуулах<br/>төсөл<br/>хэлэлцэгдс<br/>эн, шагайн<br/>аймгийн<br/>аварга<br/>шалгаруул<br/>ах тэмцээн<br/>1 удаа<br/>болсон</p> | <p>2021 онд</p>   | <p>2022<br/>онд<br/>14<br/>төрлөөр , 2024<br/>онд<br/>15<br/>төрлөөр</p>   | <p>Үндэсний спортын төрлүүдийг сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор аймгийн Шагайн холбоотой хамтран энэ оны 02 дугаар сард "Говийн бүсийн сар шинийн харваа 2024", 03 сард цолгүй харваачдын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн аварга шалгаруулах үндэсний шагайн харвааны тэмцээн, ахмадын аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээн, Өмнөговь аймгийн Даланзадгад хотын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг тус тус хамтран зохион байгуулсан.</p> | <p>100%</p> |
|  | <p><b>Арга хэмжээ-3</b><br/>Үндэсний<br/>уламжлалт спорт<br/>болох тэмээн<br/>поло, үндэсний<br/>шагайг<br/>нийтэд<br/>сурталчлах</p>         | <p>Оролцож буй баг<br/>тамирчдын<br/>тоогоор оролцсон</p>                     | <p>2020 онд<br/>бөхийн<br/>хивс,<br/>шагайн<br/>өрөөгөөр<br/>тус тус 2<br/>холбоодыг<br/>хангасан</p>  | <p>2021 онд 3,<br/>2022 онд 4,<br/>2023 онд 5,<br/>2024 онд 6</p> | <p>Үндэсний спортыг сурталчлан хөгжүүлэх ажлын хүрээнд тэмцээн уралдааныг зохион байгуулж, байгууллагын цахим хуудаст мэдээллийг тухай бүр байршуулан ажилласнаар иргэдийг үндэсний спортоор хичээллэх, монгол бахархлыг бий болгон ажиллаж байна.<br/>Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборт шагай харвааны ерөө байрлаж, ахмад харваачид, залуучууд, шагай сонирхогчид бэлтгэл сургуулилт</p> | <p>100%</p>  |             |
|  | <p><b>Арга хэмжээ-4</b><br/>Үндэсний<br/>уламжлалт<br/>спортын<br/>холбоодын<br/>хөгжлийг дэмжих,<br/>хэрэглэл<br/>материалаар<br/>хангах</p> | <p>Хамтарч ажилласан спорт<br/>холбоодын тоо, хэрэгсэл<br/>материалын тоо</p> |  |   |  |  |             |

|   |  |  |   |  |  |      |
|---|--|--|---|--|--|------|
| 4 | <p>Зорилт-4.<br/>Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, Дэлхийн</p> | <p><b>Арга хэмжээ-1</b><br/>Насанд хүрэгчдийн шигшээ залуучуудын шигшээ багийн залгамж халааг сайжруулах, Улс, бүсийн түвшинд өрсөлдөх, өсвөрийн шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлэх</p> | <p>Өсвөрийн шигшээ багийн төрлийн тоо</p> |  | <p>хийх орчинг бүрдүүлж, үндэсний бөхийн барилдаанд бөхийн эд хэрэглэлээр ханган ажилласан. Сумдуудад иргэдийн дунд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Адуучин”, “Сурын харваа”, “Буухиа тэмцээн”, “Шагайн харваа” зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж хэвшсэн. Соёл спортын ордонтой харьяа сумдуудад /8 сум, Сайншанд сумын 5-р баг/ үндэсний бөхийн дугуйланд 756, Шагайн харвааны дугуйланд 2127, үндэсний сурын дугуйланд 1290 хүүхэд тогтмол хичээллэж байна. Нийт давхардсан тоогоор 4173 байна.</p>   |      |
|   |  |  |   |  | <p>2020 онд спортын 8 төрөлд 370 тамирчин хичээллэдэг байсан өсвөр үеийн шигшээ багийг Монгол Улсын сайд, Олимп, Нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хамтран ажиллах гэрээний дагуу спортын холбоодуудтай хамтран өсвөр үеийн шигшээ багийн спортын 12 төрлөөр хөгжүүлэн, үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Өсвөр үеийн шигшээ багт 670 гаруй тамирчид хичээллэж байна. Тус аймагт зохион байгуулагдсан “Дорноговь олон” Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын</p> | 100% |

|   |   |  |  |  |  |             |
|---|---|--|--|--|--|-------------|
| <p>түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах спортын төрлийг нэмэгдүүлэх</p> | <p><b>Арга хэмжээ-2</b><br/>Спортын цол олгох ажиллагааг спорт холбоо, клубүүдээс цол, зэрэгтэй тамирчдын мэдээллийг авч цахим бүртгэлд оруулах</p>   | <p>Цол, зэрэгтэй тамирчдын тоог цахим санд оруулах</p> | <p>2020 онд 1243 цол зэрэгтэй тамирчид</p> | <p>2021 онд 300<br/>2022 онд 300<br/>2023 онд 300<br/>2024 онд 343</p> | <p>тэмцээнд дөрвөн улсын 30-аад клубын 600 орчим тамирчин оролцсон. Улс, олон улсын болон бүсийн тэмцээн 2020 онд 1, 2022 онд 4, 2023 онд 4, 2024 онд 3 тус тус зохион байгуулагджээ.</p>  |             |
|   | <p><b>Арга хэмжээ-3</b><br/>Улс болон түүнээс дээш тэмцээн уралдаанд спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад Аймгийн засаг даргын шагналд тодорхойлж спортын багцаас мөнгөн шагналаар шагнуулах</p> | <p>Амжилт гаргасан баг тамирчдын тоо</p>               | <p>2020 онд 48 тамирчин</p>                | <p>2021 онд 55<br/>2022 онд 60<br/>2023 онд 65<br/>2024 онд 70</p>     | <p>Спортын холбоодуудаас цол зэрэгтэй тамирчдын мэдээллийг авч бүртгэл хөтлөн, баяжилт хийн ажиллаж байна.</p>   | <p>80%</p>  |
|   |   |  |  |  | <p>Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны А/171 дүгээр захирамжаар "Өсвөр үе, залуучуудын шигшээ баг"-ийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн дэмжих арга хэмжээг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуулийг ханган оролцуулсан дасгалжуулагчдыг урамшуулан, тэдний амжилтыг ахиулах зорилгоор 2022 онд</p> | <p>100%</p> |

|   |   |   |  |  |   |  |
|---|---|---|--|--|---|--|
|   |   |   |  |  | <p>амжилт гаргасан 90 тамирчин, 10 дасгалжуулагчийг, 2023 онд амжилт гаргасан 233 тамирчин 14 дасгалжуулагчийг тус тус урамшуулсан. Тайлант онд тус болзол шалгуур хангасан тамирчдыг оны эцэст урамшуулахаар төлөвлөж байна. 10 дугаар сарын байдлаар Дорноговь аймгийн тамирчид тив, дэлхий, улсын чанартай тэмцээн уралдаанаас 115 алт, 90 мөнгө, 93 хүрэл медаль хүртсэн байна.</p> |  |
| <p><b>Арга хэмжээ-4</b><br/>Сургалт- дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, мэргэшүүлэх сургалтанд дасгалжуулагч нарыг хамруулах</p> | <p>Сургалтанд хамруулах дасгалжуулагч нарын тоо</p> | <p>2020 онд<br/>ковид-19 цар тахлын улмаас сургалт явагдаагүй</p> | <p>2021 онд 2<br/>2022 онд 4<br/>2023 онд 6<br/>2024 онд 8</p> | <p>Дорноговь аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны урилгаар Монгол улсын Волейболын спортын мастер Г.Хандсүрэн, Д.Эрдэнэбулган нар 06 дугаар сарын 20-ны өдөр ирж волейболын олон улсын дүрэм, волейболын спортын техникийн талаар практик сургалт, 3 цагийн турш үзүүлэн тоглолтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтад волейбол сонирхогч 80 гаруй эмэгтэйчүүд, 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд аймгийн Сагсан бөмбөгийн холбоотой хамтран Сагсан бөмбөгийн олон улсын шүүгчийг урьж сагсан бөмбөгийн шүүгч бэлтгэх сургалтыг зохион байгуулж, нийт 24 хүн хамрагдсан.</p> | <p>100%</p>   |  |
| <p><b>Арга хэмжээ-5</b><br/>Хүүхэд, залуучуудын</p>   | <p>Зохион явуулсан тэмцээн уралдааны тоо</p>        | <p>2020 онд улсын аваргын 2,</p>                                  | <p>2021 онд 3, 11<br/>2022 онд 4, 12<br/>2023 онд 5, 13</p>    | <p>Олон Улсын болон аймаг, бүс нутгийн хэмжээнд "Сайшандын цом"-ын өсвөрийн дугуйчдын</p>  | <p>100%</p>   |  |

|  |  |   |   |                                   |                       |   |
|--|--|---|---|-----------------------------------|-----------------------|---|
|  |  | <p>спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд аймгийн хэмжээнд спортын наадам, аймаг, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгох</p> | <p>Өсөврийн шигшээ багийн медалын чанар, амжилт</p> | <p>аймгийн аваргын 10 тэмцээн</p> | <p>2024 онд 6, 14</p> | <p>аварга шалгаруулах тэмцээн, "Жюу жицү"-ийн "Дорноговь орен" Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон Улсын тэмцээн, "Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guus" сагсан бөмбөгийн лигийн тэмцээн, Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн, чөлөөт, жүдо бөхийн тэмцээн, даам, шатрын өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, боксын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 100 жилийн ойд зориулсан сагсан бөмбөг, волейболын тэмцээн зэрэг 100 удаагийн тэмцээнд /аймгийн төвд 39, сумдад 61/5836 тамирчдыг оролцуулан, спортын үйл ажиллагаанд 33123 иргэнийг хамруулсан.</p> <p>Биеийн тамир, спортын газар 2024 онд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын 12 төрлөөр (сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг, жоу жицу зэрэг) сургалт, Дугуйлан хичээллүүлж, аймгийн өсвөр үеийн 12 шигшээ багт 670 гаруй тамирчид тогтмол хичээллэж байна.</p> <p>Тайлант онд аймгийн Биеийн тамир, спортын газар спортын 24 холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, жоу жицу зэрэг спортын 11 төрлөөр</p> <p>100%</p> |
| <p><b>Арга хэмжээ-6</b><br/>Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний хийх болон өсвөр үеийн шигшээ багт хүрч ажиллах</p> |  |   |   |                                   |                       |   |



|   |   |                       |   |             |   |
|---|---|-----------------------|---|-------------|---|
|   |   |                       |   |             | <p>сургалт, дугуйлан хичээллүүлж байгаас өсвөр үеийн 11 шигшээ багийг бүрдүүлэн 670 гаруй тамирчин тогтмол хамрагдаж байна. 2024 онд Тив, Дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээнд 105 алт, 90 мөнгө, 87 хүрэл медаль хүртсэн.</p> <p>Шинэ тутам хөгжиж буй Кудо бөхийг аймаг орон нутагтаа хөгжүүлэх зорилгоор секц, дугуйлан хичээллүүлж давхардсан тоогоор 360 хүүхэд хичээллэж байна.</p> <p>Говь-Сүмбэр аймагт зохион байгуулагдсан шинэ спортын төрөл крикетийн спортыг хөгжүүлэх анхан шатны сургалтанд ахлах мэргэжилтэн, нийтийн биеийн тамирын арга зүйч нар оролцсон. Цаашид аймаг орон нутагтаа тус спортыг хөгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Говь-Сүмбэр аймагт зохион байгуулагдсан шинэ спортын төрөл крикетийн спортыг хөгжүүлэх анхан шатны сургалтанд ахлах мэргэжилтэн, нийтийн биеийн тамирын арга зүйч нар оролцсон. Цаашид аймаг орон нутагтаа багийн спортын төрлийг нэмэгдүүлж тус спортыг хөгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Сагсан бөмбөг, волейбол зэрэг багийн спортыг аймаг орон</p> |
| <p><b>Арга хэмжээ-7</b><br/>Шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.</p> | <p>Шинээр хөгжиж буй спортын төрлийн тоо</p>                                      | <p>2020 онд 1</p>     | <p>2021 онд 1<br/>2022 онд 1<br/>2023 онд 2<br/>2024 онд 2</p>  | <p>80%</p>  |   |
| <p><b>Арга хэмжээ-8</b><br/>Биеийн тамир, спортын ажил үйлчилгээний хүн амд үзүүлэх нэр төрлийг багийн спортын төрлөөр нэмэгдүүлэх</p>  | <p>Багийн спортын төрлийг 30 хувиар нэмэгдүүлэх, хэрэглэл материалаар хангах,</p> | <p>60 хувь хүрсэн</p> | <p>2021 онд 5 хувьд 2022 онд 5 хувьд 2023 онд 10 хувьд 2024 онд 10 хувьд тогтмолжуулах, хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх</p> | <p>100%</p> |   |

|  |   |                       |   |   |   |  |
|--|---|-----------------------|---|---|---|--|
|  |   |                       |   |   | <p>нутагаа хурдацтай хөгжүүлэх чиглэлээр санал санаачилга гарган ажиллаж төвийн болон сумдад хичээллэдэг секц дугуйлан болон заалыг бөмбөг, тор, тоног төхөөрөмжөөр хангасан.</p> |  |
| <p><b>Арга хэмжээ-9</b><br/>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах</p> | <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагааг 30 хувь нэмэгдүүлэх</p> | <p>10 хувь хүрсэн</p> | <p>2021 онд 5 хувьд 2022 онд 5 хувьд 2023 онд 10 хувьд 2024 онд 10 хувьд тогтмолжуулах, хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх</p>   | <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зорилгоор шатар, даам болон, нисдэг таваг, волейболын тэмцээнд 2 багийн 20 тамирчид оролцсноос Биеийн тамир, спортын газраас заалаар үнэгүй үйлчилсэн. Мөн 96,000 тегрэгний дэмжлэг үзүүлсэн. "Хонхот бөмбөг"-ийн бүсийн тэмцээнд оролцсон тамирчдад Биеийн тамир, спортын газар 1 сая тегрэгний дэмжлэг үзүүлсэн.</p>  | <p>100%</p>   |  |
| <p><b>Арга хэмжээ-10</b><br/>Ахмад настны спортын үйл ажиллагаанд хамруулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах</p>                        | <p>Ахмад настны иргэдийг спортын үйл ажиллагааг 90 хувь хүргэх</p>              | <p>70 хувь хүрсэн</p> | <p>2021 онд 75 хувьд 2022 онд 80 хувьд 2023 онд 85 хувьд 2024 онд 90 хувьд тогтмолжуулах, хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх</p> | <p>Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборт шагай харвааны өрөөг тохижуулж, ахмад болон залуучуудын баг, шагай сонирхогчид бэлтгэл сургуулилт хийх орчинг бүрдүүлж, үндэсний бөхийн барилдаанд бөхийн эд хэрэглэлээр ханган ажилласан. Шагайн харвааны дугуйланд давхардсан тоогоор 2127 харваачид хамрагдаж байна. Мөн ахмадын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, софт волейболын цомын аварга шалгаруулах тэмцээн, Дорноговь аймгийн Айраг сумын уугуул</p> | <p>100%</p>   |  |

|   |  |   |  |  |  |  |  |  |      |
|---|--|---|--|--|--|--|--|--|------|
|   |  |   |  |  |  |  |  | аймгийн заан Г.Сэр-Од агсны нэрэмжит Софт волейболын ахмадын аварга шалгаруулах тэмцээн тус тус зохион байгуулсан.   |      |
| <b>Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах</b> |  |   |  |  |  |  |  |  |      |
| <b>Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүрэг</b>                            |  |   |  |  |  |  |  |  |      |
|   |  | <b>Арга хэмжээ-1</b><br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хууль, журамд заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх  | Тухай жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр  |  |  |  |  | 2023 болон 2024 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн тайланг харьяалах дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн болно.   | 100% |
|   | <b>Зорилт-5.</b><br>Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйлчилгээний албан хаагчдын хүний нөөцийг чадавхжуулах | <b>Арга хэмжээ-2</b><br>Спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах, спортын холбоо, клубүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх | Тухай жилийн байгууллагын тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээгээр   |  |  |  |  | 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний Биеийн тамир, спортын улсын хороо 88,7, аймгийн Засаг даргаас 86,5 хувьтай үнэлэгдсэн болно.   | 100% |
| 5   |  | <b>Арга хэмжээ-3</b><br>Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн   | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо хувь, |  |  |  | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн | “Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж хөтөлбөрийн биелэлт 96,2 хувьтай байна. 2024 оны 11 сарын байдлаар давхардсан | 100% |

|  |  |   |  |  |   |
|--|--|---|--|--|---|
|  |  | <p>баталгааг<br/>хангахад дэмжлэг<br/>үзүүлэх, чадавхыг<br/>дээшлүүлэх,<br/>мэргэшүүлэх<br/>сургалтад<br/>хамруулах</p> |  | <p>хэрэгжилтийн<br/>хувь,<br/>мэргэшүүлэх<br/>сургалтад<br/>хамрагдсан<br/>ажилтны тоо</p> | <p>тоогоор 46 албан хаагч,<br/>ажилтнуудад ажлын үр дүнгээр<br/>20-50 хувийн мөнгөн урамшуулал,<br/>172 ажилтанд үр чадварын<br/>нэмэгдэл, хоол унааны зардал,<br/>орон нутгийн нэмэгдэл нийт<br/>албан хаагч, ажилтнуудад<br/>олгосон. Өндөр насны тэтгэвэр<br/>тогтоолгосон 1 ахмад ажилтан,<br/>аав, ээж, төрсөн ах нь нас барсан<br/>3 албан хаагчид нэг удаагийн<br/>буцалтгүй тусламж олгон<br/>ажилласан. Хаврын тэргүүн<br/>сарын шинийн нэгэн "Цагаан сар",<br/>Ахмадын баярыг тохиолдуулан<br/>байгууллагын 14 ахмад настан,<br/>Олон улсын эмэгтэйчүүдийн<br/>эрхийг хамгаалах өдөр"-ийг<br/>тохиолдуулан тус газарт<br/>ажилладаг эмэгтэй албан хаагч,<br/>олон улсын хүүхдийн эрхийг<br/>хамгаалах өдрүүдэд<br/>ажилтнуудын хүүхдүүдэд тусгай<br/>хөтөлбөрийн дагуу хүндэтгэл<br/>үзүүлж бэлэг дурсгалын зүйл<br/>гардуулах арга хэмжээг тус тус<br/>зохион байгуулсан. Ажилтнуудыг<br/>хөдөлгөөний дутагдлаас<br/>сэргийлэх зорилгоор 7 хоног<br/>бүрийн Лхагва гарагт спорт<br/>зааланд бие бялдарын<br/>бэлтгэлжилтэнд хамрагдаж,<br/>эрүүл аж төрөх, зөв хооллолтын<br/>талаар ажилтнуудад сургалтыг<br/>оруулж, багуудын хооронд<br/>спортын тэмцээн уралдааныг<br/>зохион байгуулж ажилласан. Мөн<br/>албан хаагчдын ажиллах</p> |
|--|--|---|--|--|---|

|   |   |  |  |                           |                             |   |   |      |
|---|---|--|--|---------------------------|-----------------------------|---|---|------|
| 6 | Зорилт-6.<br>Төвлөрүүлэн захирагчийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хууль | <b>Арга хэмжээ-1</b><br>Биеийн тамир, спортын газрын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах | Тухай жилийн улсын болон орон нутгийн батлагдсан төсөв | 2020 онд батлагдсан төсөв | Жил бүрийн батлагдсан төсөв | <p>нехцелийг сайжруулж өрөө тасалгаа, амралтын өрөөг тохижуулж, үйлчилгээний ажилтнуудыг 2 ээлжийн ажлын хувцсаар ханган ажилласан. Ажилтнуудын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан "Хамтын сан"-гаас давхардсан тоогоор давхардсан тоогоор 48 ажилтанд төгрөгийн 2,350,000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлж, гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс авахад тусламж үзүүлсэн. БТСУХорооноос зохион байгуулсан чадавхжуулах сургалтанд биеийн тамирын арга зүйч нарыг хамруулж мэргэшүүлэн ажиллаж байна.</p> | <p>Биеийн тамир спорт хөтөлбөрийн хүрээнд Урсгал зардал, Нийтийн биеийн тамир, Биеийн тамирын уралдаан тэмцээн гэсэн зориулалт, арга хэмжээг хэрэгжүүлэх 1,115,349.7 мян.төг 2024 онд улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан. Төсвийн гүйцэтгэлийн 2024 оны 11 сарын өссөн дүнгээр 952,921.6 сая төгрөгийн санхүүжилт авсанаас батлагдсан арга хэмжээнүүдийг санхүүжлэхэд нийт 281,438.09 төгрөгийн зарцуулалт хийгдсэн. Үүнээс урсгал зардалд 679,128.9 мян.төг, Биеийн тамир уралдаан тэмцээний арга хэмжээний зардалд 40,644.2</p> | 100% |
|---|---|--|--|---------------------------|-----------------------------|---|---|------|

|   |  |   |   |   |   |  |      |
|---|--|---|---|---|---|--|------|
| 7 | Зорилт-7.<br>Биеийн тамир,<br>спортын<br>газрын гадаад | Арга хэмжээ-1<br>Биеийн тамир,<br>спортын<br>чиглэлээр гадаад | Биеийн тамир, спортын<br>чиглэлээр гадаад улсын<br>засгийн газар болон бусад<br>ижил төстэй | 2020 онд<br>Засгийн<br>газар<br>хоорондын | 2021-2024 онд<br>тус бүр<br>хамтын<br>ажиллагааны | <p>мян.төг, Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг арга хэмжээнд 15,281.6 мян.төг, Нийтийн биеийн тамир арга хэмжээг хэрэгжүүлэхэд 29,066.6 мян.төг тус тус зарцуулсан байна. Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газраас байр ашиглалттай холбоотой тогтмол задлын санхүүжилтэд 2024 онд 572,304.7 төгрөгийн төсөв батлагдсанаас 11 сарын өссөн дүнгээр 493,959.0 мян.төг –ийн санхүүжилтыг хүлээн авч гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардалд 563,197.1 мян.төг-ийн зарцуулалтыг тайлагнасан. 11 сарын байдлаар ер, авлаг үүсээгүй байна. Дорноговь аймгийн Засаг даргын 2024.01.19-ны өдрийн А/111 санхүүжилт олгох тухай захирамжаар 9 сумын биеийн тамир, спортын газрын албан хаагчдын 2024 оны цалингийн санхүүжилтэд 629,343.4 мян.төг олгохоор шийдвэрлэгдсэн ба 2024 оны 11 сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 584,037.8 мян.төг-ийн санхүүжилтыг авч сумдын албан хаагчдыг цалинжуулан ажиллаж байна.</p> <p>Спортын холбоотой хамтран Дорноговь олон Жюу жицүгийн олон улсын нээлттэй тэмцээн, ОХУ-ын Надым хотноо зохион</p> | 100% |
|---|--|---|---|---|---|--|------|

|  |   |  |   |   |   |      |
|--|---|--|---|---|---|------|
| харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх  | улсын ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, хэрэгжилтийг хангуулах          | байгууллагуудтай хамтын ажиллагааны 4 баримт бичиг байгуулах   | 5 баримт бичиг, ижил түвшний байгууллага а 11 баримт бичиг  | 1 баримт бичиг байгуулах  | байгуулагдсан олон улсын тэмцээн, аймгийн Засаг даргын нэрэмжит холимог насны боксчдын аварга шалгаруулах "ДОРНОГОВЬ ЦОМ-2024" олон улсын нээлттэй тэмцээнийг тус тус зохион байгуулсан.  |      |
| <b>Арга хэмжээ-2</b><br>Биеийн тамир, спортын гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулах                                 | Биеийн тамир, спортын дотоод, гадаад хамтын ажиллагааны хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулах             |  |   | Спортын холбоодтой хамтран Дорноговь олен Жюу жицүгийн олон улсын нээлттэй тэмцээн, ОХУ-ын Надым хотноо зохион байгуулагдсан олон улсын тэмцээн, аймгийн Засаг даргын нэрэмжит холимог насны боксчдын аварга шалгаруулах "ДОРНОГОВЬ ЦОМ-2024" олон улсын нээлттэй тэмцээнийг тус тус зохион байгуулсан. | 100%  |      |
| Зорилт-8.<br>Биеийн тамир, спортын газрын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | <b>Арга хэмжээ-1</b><br>Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулах | Биеийн тамир, спортын байгууллага, спортын холбоодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, дүгнэлтээр хангасан 25 тоо | 25 спортын холбоо, клубүүдийн үйл ажиллагаа нд зөвлөн туслах арга хэмжээг хэрэгжүүлж зөвлөмж өгсөн. |   | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөн хийж байна. | 100% |
|  | <b>Арга хэмжээ-2</b><br>Биеийн тамир, спортын газрын бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-                        | Биеийн тамир, спортын газрын бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээг хийх  |   |   | 2023 оны 12 дугаар сард байгууллагын жилийн эцсийн үйл ажиллааны үр дүнд хяналт шалгалт үнэлгээ хийсэн тайланг БТСУХороонд хүргүүлсэн. 2024 оны тайланг гаргаж 12 дугаар  | 100% |

|   |   |  |   |  |  |  |   |     |
|---|---|--|---|--|--|--|---|-----|
|   |   |  |   |  |  |  | сарын 15-ны дотор ирүүлсэн албан бичгийн дагуу хургуулгах болно.  |     |
| 9 | Зорилт-9.<br>Биеийн тамир,<br>спортын<br>газрын<br>хэмжээнд<br>дотоод<br>аудитын<br>тогтолцоог<br>бэхжүүлэн<br>сайжруулах | <b>Арга хэмжээ-1</b><br>Төсвийн<br>төвлөрүүлэн<br>захирагчийн<br>эрхлэх асуудлын<br>хүрээний<br>байгууллагад<br>эрсдэлд<br>суурилсан<br>төвлөгөөт<br>болон<br>төвлөгөөт бус<br>дотоод аудит хийх | Эрсдэлд суурилсан төвлөгөөт аудит, хяналт шалгалтыг 1 хийлгэх |  |  |  | Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу Биеийн тамир спортын газрын үйл ажиллагааны онцлог нийцүүлэн дотоод хяналт шалгалтын журам батлан хэрэгжилтийн ханган 2024 оны эхний хагас жилд газрыг даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж, сүүлийн хагас жилийн шалгалтыг явуулж дуусаагүй байгаа болно. | 80% |

Нийт оноо: 3230 /34 ажил, арга хэмжээ/

Дундаж хувь: 95.0%

Үнэлгээ-4,75

ТАЙЛАН ХЯНАСАН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН АРГА ЗҮЙН

Г. БАТЛХАМ

Ч. ОТГОНЧУЛУУН

